



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас/Факс: (976) 7011-3033
<http://www.edub.edu.mn>

2019.09.10 № 4/1421
танай _____-ны № _____-г

Удирдамж хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш. Анхмаагийн баталсан “Хүүхдийн байгууллагад халдварт өвчний эрсдлийн үнэлгээг түүвэрчлэн хийх” тухай удирдамжийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 1/842 тоот албан бичгийн хамт хүргүүлж байна.

Иймд удирдамжийг нэр бүхий сургууль, цэцэрлэгт хүргүүлэн хуваарийн дагуу тухайн сургууль, цэцэрлэгийг бүрэн хамруулж ажиллана уу.

Жич: Дүүрэг тус бүрээс нэг мэргэжилтэн тухайн өдрүүдэд хариуцан ажиллана.

Хавсралт 4 хуудас

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА *С.Ганчимэг* С.ГАНЧИМЭГ





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2019.09.07 № 1/842

танай _____ -ны № _____ -г

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаагийн баталсан "Хүүхдийн байгууллагад халдварт өвчний эрсдлийн үнэлгээг түүвэрчлэн хийх тухай" удирдамжийг хавсралтаар хүргүүлж байна.

Удирдамжид заасан хуваарийн дагуу үнэлгээг хийхэд холбогдох мэргэжилтнээ оролцуулах, мөн удирдамжийг үнэлгээнд хамрагдах сургууль, цэцэрлэгт хүргүүлэн чиглэл өгч бидэнтэй хамтран ажиллана уу.


Хавсралт.....хуудастай.

ДАРГА  Л.ТӨМӨРБААТАР



1150500908

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ОРГЫН ХЭНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЧ АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ш.АНХМАА



2019 оны 06 дугаар сарын ...ны өдөр

ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭГ ТҮҮВЭРЧИЛЖ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл

Сургуулийн орчин, эрүүл ахуйн нөхцөл байдал нь хүүхдийн эрүүл мэндэд шууд нөлөөлж, халдварт өвчнөөр өвдөх нэг эрсдэлт хүчин зүйл болдог тул сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд зохистой орчин, дадал хэвшлийг бий болгох асуудлыг дэлхийн аль ч орон чухалчлан авч үздэг билээ.

Улсын хэмжээнд 2018 онд 27 төрлийн 42.074 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэнээс (10.000 хүн амд 132.4) Нийслэлд халдварт өвчний 54% буюу (10.000 хүн амд 163.9) 22.931 тохиолдол бүртгэгдсэн нь Улсын дунджаас өндөр хэмжээнд байна.

Нийслэлийн хэмжээнд нийт халдварт өвчний тохиолдлын тоо (2016-39.517, 2017-26.808, 2018-22.931) сүүлийн 3 жилийн байдлаар буурах хандлагатай байгаа боловч өвчний төрлүүдээр авч үзвэл салхинцэцэг (2016-15.5%, 2017-57.5%, 2018-58.6%), цусан суулга (2016-32.5%, 2017-42.8%, 2018-66.7%) өвчнүүд 0-9 насны хүүхдүүдийн дунд он дараалан нэмэгдэж байна.

2019 оны эхний 5 сарын байдлаар 100-аас дээш хүн хамарсан гэдэсний халдварын 4 томоохон дэгдэлт гарснаас 2 нь ерөнхий боловсролын сургуульд гарсан байна.

Нийт халдварт өвчний дотор 59.3 хувийг 0-5 буюу цэцэрлэгийн насны, 20.4 хувийг сургуулийн 6-15 насны хүүхдүүдийн өвчлөл эзэлж, өвчний төрлөөр гэдэсний халдвар, амьсгалын замын халдвар зонхилон тохиолдож байна.

Гэдэсний халдвараас цусан суулга өвчин 20.8% (n=2181), бактерийн гаралтай хоолны хордлого 6.5% (n=687), амьсгалын замын халдвараас улаан эсэргэнэ 4.4% (n=461), салхинцэцэг өвчин 6.5% (n=682) өндөр үзүүлэлттэй давамгайлж байна.

Тархалтын байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй дүүрэгт өндөр байна. Гэдэсний халдварт өвчний дамжих замын ихэнхи хувь нь бохир гар, бохир орчноор, амьсгалын замын халдварт өвчнүүд нь агаар, дуслын замаар халдварладаг тул хүүхдийн байгууллагын гар угаах нөхцөл байдал, дадал, хэвшил, орчны эрүүл ахуй, агааржуулалт, цэвэрлэгээ үйлчилгээний байдал нь эрсдэлт хүчин зүйл болдог.

Дээрх эрсдэлт хүчин зүйлс болон эмч нарын дотоод хяналт, үйл ажиллагаанд үнэлгээ өгч халдварт өвчин гарах, тархахад нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлон санал зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэн, салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцон, хамтран ажиллах шаардлагатай байна.

ДӨЛӨӨ ГИЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Харьяалах дүүрэг	Хүүхдийн байгууллага	Хугацаа	Ажлын хэсгийн гишүүн
1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага				
1	Баянзүрх дүүрэг / 9 цэцэрлэг /	3, 6, 21, 32, 61, 82, 115, 122, 129 дүгээр цэцэрлэг	IX/9-IX/13	1-р баг
2	Сонгинохайрхан дүүрэг / 9 цэцэрлэг /	26, 38, 80, 91, 101, 105, 158, 192 259 дүгээр цэцэрлэг	IX/16- IX/20	1-р баг
3	Хан-Уул дүүрэг / 10 цэцэрлэг /	27, 35, 41, 46, 65, 67, 209, 218, 230, 243 дугаар цэцэрлэг	IX/9- IX/13	2-р баг
4	Баянгол дүүрэг / 4 цэцэрлэг /	93, 94, 96, Амила цэцэрлэг	IX/23- IX/24	2-р баг
5	Сүхбаатар дүүрэг / 6 цэцэрлэг /	16, 51, 68, 109, 135, 216 дугаар цэцэрлэг	IX/23- IX/25	1-р баг
6	Чингэлтэй дүүрэг / 9 цэцэрлэг /	4, 5, 9, 31, 83, 124, 155, 174, 245 дугаар цэцэрлэг	IX/16- IX/20	2-р баг
Нийт		47		
2. Ерөнхий боловсролын сургууль				
1	Сонгинохайрхан дүүрэг / 5 сургууль /	12, 42, 65, 67, 80 дугаар сургууль	X/23- X/25	2-р баг
2	Чингэлтэй дүүрэг / 6 сургууль /	5, 17, 23, 39, 49, 117 дугаар сургууль	X/23- X/25	1-р баг
3	Хан-Уул дүүрэг / 4 сургууль /	15, 32, 52, 115 дугаар сургууль	X/1- X/3	2-р баг
4	Баянзүрх дүүрэг / 7 сургууль /	14, 48, 53, 97, 120, Абсолют, Сингапур сургууль	X/1- X/5	1-р баг
Нийт		22		

Найм. Зохион байгуулагч: Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Боловсролын газар

Ес. Хүлээгдэж буй үр дүн

Удирдамжийн дагуу судалгааг зохион байгуулж, үнэлгээний тайланг нэгтгэн, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт боловсруулан холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлнэ.

Зорилго:

Хүүхдийн байгууллагад бүртгэгдэж байгаа халдварт өвчний тохиолдлыг сургалтын орчны ариун цэвэр, эрүүл ахуй нөхцөл, аюулгүй орчинтой холбон судалж, эрсдлийг үнэлэх

Хамрах хүрээ:

Нэг голомтонд халдварт өвчний гурваас дээш тохиолдол, алаг цоог тархалт бүртгэгдсэн ерөнхий боловсролын 22 сургууль, 47 цэцэрлэгийг тандалт судалгаанд хамруулна.

Үйл ажиллагаа

Нийслэлийн Эрүүл мэндийн газар

1. Сургуулийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, цэвэрлэгээ үйлчилгээнд үнэлгээ өгөх
2. Гар угаах дадал, хандлагыг үнэлэх
3. Угаах, халдваргүйтгэх бодисын хүрэлцээнд үнэлгээ өгөх

Нийслэлийн Боловсролын газар

1. Удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтын үйл ажиллагааг шалгах, үнэлэх
2. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийх

Үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

	Н.Мэндсайхан	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ахлах мэргэжилтэн
1-р баг	Ц.Ундрал Д.Нямсүрэн	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Марзия	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн тархвар судлагч.
2-р баг	Э.Гэрэлмаа	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
	<i>Г. Алтантуяа</i> Б.Энхтайван Н.Гантуяа	Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Тархвар судлагч.

Зургаа. Хугацаа

2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны хооронд
2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны хооронд